



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баяннуур сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/157/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2022 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр: Утас: 70342580 Цахим хаяг: Ankhbayard@audit.dov.mn</p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn</p> <p>Аудитор: Б.Энхтөр Утас: 70342495 Цахим хаяг: Enkhturb@audit.gov.mn</p>
------------------------------------------------------------------------------------------------------	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4-15
3. Аудитын тайлан.....	15-18
3.1 Ерөнхий зүйл.....	
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	
3.4 Материаллаг байдал.....	
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	
3.8 Аудитын гол асуудал.....	
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	
4. Аудитын илрүүлэлт.....	18-19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	19



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 61
танай _____ ны № _____ т

БЯАННУУР СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ч.САРАНТУЯА ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баяннуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баяннуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:/bichighereg/2022A4foot

• 006020077

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4toot

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

ТӨБЗГ Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>71,916,515.00</u>	<u>25,290,828.28</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	71,916,515.00	25,290,828.28
351	Түүхий эд материал	5,280,860.00	908,640.00
35110	Тусгай зориулалттай материал	4,138,270.00	531,440.00
35130	Эм боох материал	1,142,590.00	377,200.00
354	Хангамжийн материал	66,635,655.00	24,382,188.28
35410	Бичиг хэргийн материал	744,500.00	523,000.00
35420	Аж ахуйн материал	36,517,834.95	20,045,938.23
35460	Хүнсний материал	2,481,920.05	3,813,250.05
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,426,091,701.26</u>	<u>1,361,166,477.81</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,426,091,701.26	1,361,166,477.81
392	Биет хөрөнгө	1,395,937,701.26	1,331,012,477.81
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,429,211,567.49	1,429,211,567.49
39202	Хуримтлагдсан элэгдэл	(129,340,247.16)	(191,610,324.26)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	7,845,000.00	7,845,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1,569,000.00)	(3,138,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	84,142,735.00	82,304,098.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(27,741,455.96)	(26,385,119.93)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	48,905,170.77	43,571,055.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(23,109,248.06)	(20,022,890.33)
39214	Бусад үндсэн хөрөнгө	21,370,140.00	21,370,140.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(15,497,525.57)	(17,050,396.61)
39217	Ном	1,720,564.75	4,917,347.95
393	Биет бус хөрөнгө	30,154,000.00	30,154,000.00
39301	Программ хангамж	1,700,000.00	1,700,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	28,454,000.00	28,454,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,498,008,216.26</u>	<u>1,386,457,306.09</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,498,008,216.26</u>	<u>1,386,457,306.09</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,498,008,216.26	1,386,457,306.09
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	232,416,592.14	232,416,592.14
51101	Өмч: - төрийн	28,454,000.00	28,454,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	(69,878,505.27)	(181,429,415.44)
51210	Өмнөх үеийн үр дүн	(69,878,505.27)	(69,878,505.27)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(111,550,910.17)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,335,470,129.39	1,335,470,129.39
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,498,008,216.26</u>	<u>1,386,457,306.09</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	648,867,339.75	719,353,144.48

Баяннуур сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,115,939.75	6,640,505.48
120	Нийтлэг татварын бус орлого	8,115,939.75	6,640,505.48
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,115,939.75	6,640,505.48
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	8,115,939.75	6,640,505.48
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	640,751,400.00	712,712,639.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	613,284,300.00	604,798,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	604,798,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,449,080.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,449,080.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	27,467,100.00	106,465,059.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	27,467,100.00	106,465,059.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	720,954,603.59	827,446,214.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	720,954,603.59	827,446,214.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	637,501,571.16	771,799,960.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	431,784,020.22	455,002,279.36
210101	Үндсэн цалин	277,609,742.14	258,219,955.58
210102	Нэмэгдэл	131,006,490.36	162,070,871.31
210104	Урамшуулал	23,167,787.72	34,711,452.47
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,324,531.75	51,534,300.69
210201	Тэтгэврийн даатгал	44,825,359.90	35,510,764.05
210202	Тэтгэмжийн даатгал	3,274,908.35	3,972,121.53
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,391,191.58	3,177,696.98
210204	Ажилгүйдлийн даатгал	532,617.48	929,475.66
210205	Эрүүл мэндийн даатгал	4,300,454.44	7,944,242.47
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,959,435.00	106,173,959.00
210301	Гэрэл, цахилгаан	4,473,224.00	4,449,759.00
210302	Түлш, халаалт	22,486,211.00	101,724,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,831,900.00	32,302,886.00
210401	Бичиг хэрэг	79,800.00	485,480.00
210402	Тээвэр, шатахуун	2,250,000.00	2,016,214.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	359,000.00	469,000.00
210404	Ном, хэвлэл	-	2,112,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,541,100.00	2,153,392.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	602,000.00	25,066,400.00
2105	Нормативт зардал	19,747,120.00	28,759,060.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	149,960.00	327,340.00
210502	Хоол, хүнс	18,409,350.00	17,673,770.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,187,810.00	10,757,950.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	584,200.00	903,500.00
210604	Урсгал засвар	584,200.00	903,500.00
2107	Томилолт, зочны зардал	657,000.00	290,000.00
210702	Дотоод албан томилолт	657,000.00	290,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	887,400.00	414,150.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	563,400.00	414,150.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	97,725,964.19	96,419,825.65
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,013,200.00	12,277,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,531,400.00	3,386,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	87,181,364.19	80,756,025.65
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	83,453,032.43	55,646,253.95
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,866,400.00	18,335,330.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,001,460.00	17,915,330.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	864,940.00	420,000.00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	72,586,632.43	37,310,923.95
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	72,586,632.43	37,310,923.95
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(72,087,263.84)	(108,093,070.17)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	172,893.72	3,457,840.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	172,893.72	3,457,840.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(172,893.72)	(3,457,840.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(72,260,157.56)	(111,550,910.17)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	232,416,592.14	1,335,470,129.39	2,381,652.29		1,570,268,373.82
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	232,416,592.14	1,335,470,129.39	2,381,652.29	-	1,570,268,373.82
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-		-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(72,260,157.56)		(72,260,157.56)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	232,416,592.14	1,335,470,129.39	(69,878,505.27)	-	1,498,008,216.26
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	232,416,592.14	1,335,470,129.39	(69,878,505.27)	-	1,498,008,216.26
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	232,416,592.14	1,335,470,129.39	(69,878,505.27)	-	1,498,008,216.26
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-		-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-		-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(111,550,910.17)		(111,550,910.17)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	232,416,592.14	1,335,470,129.39	(181,429,415.44)	-	1,386,457,306.09

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	640,751,400.00	712,712,639.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	640,751,400.00	712,712,639.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	613,284,300.00	604,798,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	604,798,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,449,080.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,449,080.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	27,467,100.00	106,465,059.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	27,467,100.00	106,465,059.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	637,501,400.00	702,443,639.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	637,501,400.00	702,443,639.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	552,877,187.57	649,236,875.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	430,871,950.82	447,327,760.52
210101	Үндсэн цалин	267,656,859.74	265,811,425.97
210102	Нэмэгдэл	111,426,442.08	147,124,693.28
210104	Урамшуулал	51,788,649.00	34,391,641.27
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,324,531.75	58,038,719.53
210201	Тэтгэврийн даатгал	44,861,828.90	41,605,958.23
210202	Тэтгэмжийн даатгал	3,629,196.14	4,108,240.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,391,191.58	3,286,512.20
210204	Ажилгүйдлийн даатгал	141,860.69	821,727.92
210205	Эрүүл мэндийн даатгал	4,300,454.44	8,216,280.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,422,685.00	105,565,559.00
210301	Гэрэл, цахилгаан	4,473,224.00	4,449,759.00
210302	Түлш, халаалт	21,949,461.00	101,115,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,811,700.00	5,556,586.00
210401	Бичиг хэрэг	254,800.00	466,480.00
210402	Тээвэр, шатахуун	2,250,000.00	2,023,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	359,000.00	469,000.00
210404	Ном, хэвлэл	307,200.00	265,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,453,000.00	1,332,906.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,187,700.00	999,700.00
2105	Нормативт зардал	18,316,420.00	23,146,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	244,400.00	429,400.00
210502	Хоол, хүнс	16,613,020.00	21,295,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,459,000.00	1,421,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	885,200.00	899,500.00
210604	Урсгал засвар	885,200.00	899,500.00
2107	Томилолт, зочны зардал	657,000.00	290,000.00
210702	Дотоод албан томилолт	657,000.00	290,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,026,800.00	147,150.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	702,800.00	147,150.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,560,900.00	8,265,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,063,200.00	4,668,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,497,700.00	3,597,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	84,624,212.43	53,206,763.95
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,037,580.00	15,895,840.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,218,580.00	15,475,840.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	819,000.00	420,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	72,586,632.43	37,310,923.95

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	72,586,632.43	37,310,923.95
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	3,250,000.00	10,269,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	3,250,000.00	10,269,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,250,000.00	10,269,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,250,000.00	10,269,000.00
222001	Тоног төхөөрөмж	3,250,000.00	10,269,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(3,250,000.00)	(10,269,000.00)

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

ТГ

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	0.00	712658500.00	673952635.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	0.00	712658500.00	663683635.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	0.00	695883100.00	647787795.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	0.00	462212500.00	447327760.52
210101	Үндсэн цалин	0.00	0.00	278424400.00	265811425.97
210102	Нэмэгдэл	0.00	0.00	150012700.00	147124693.28
210104	Урамшуулал	0.00	0.00	33775400.00	34391641.27
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	0.00	62403200.00	58038719.53
210201	Тэтгэврийн даатгал	0.00	0.00	43874900.00	41605958.23
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	0.00	4606100.00	4108240.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	0.00	3731600.00	3286512.20
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	0.00	926400.00	821727.92
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	0.00	9264200.00	8216280.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	0.00	106960000.00	105565559.00
210301	Гэрэл, цахилгаан	0.00	0.00	4800000.00	4449759.00
210302	Түлш, халаалт	0.00	0.00	101680000.00	101115800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	0.00	5116300.00	5107506.00
210401	Бичиг хэрэг	0.00	0.00	337400.00	337400.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	0.00	2023000.00	2023000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	-	472,800.00	469,000.00
210404	Ном, хэвлэл	-	-	270,100.00	265,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	-	1,013,000.00	1,012,906.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	-	1,000,000.00	999,700.00

2105	Норматив зардал	-	-	40,259,100.00	23,146,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	-	429,400.00	429,400.00
210502	Хоол, хүнс	-	-	38,407,900.00	21,295,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	-	1,421,800.00	1,421,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	-	9,200,000.00	899,500.00
210604	Урсгал засвар	-	-	900,000.00	899,500.00
2107	Томилолт, зочны зардал	-	-	337,400.00	290,000.00
210702	Дотоод албан томилолт	-	-	337,400.00	290,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	-	160,200.00	147,150.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	-	160,200.00	147,150.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-	9,234,400.00	7,265,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-	3,668,000.00	3,668,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	-	5,566,400.00	3,597,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	-	16,775,400.00	15,895,840.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-	16,775,400.00	15,895,840.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	-	16,355,400.00	15,475,840.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	-	420,000.00	420,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-	-	10,269,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	-	-	10,269,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	-	-	10,269,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-	-	711,263,559.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-	-	604,798,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	-	-	604,798,500.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-	-	106,465,059.00
132001	Орон нутгийн төсвөөс	-	-	-	106,465,059.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	1.00
610001	Төсвийн байгууллага	-	-	-	1.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	-	-	-	38.00
620001	Удирдах ажилтан	-	-	-	3.00

620002	Гүйцэтгэх ажилтан	-	-	-	16.00
620003	Үйлчлэх ажилтан	-	-	-	15.00
620004	Гэрээт ажилтан	-	-	-	4.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	-	-	-	286.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	-	-	-	286.00
630001	Төрийн өмчит ЕБС	-	-	-	286.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	-	-	-	38.00
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	-	-	-	19.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	-	-	-	15.00
650010	Гэрээт ажилтан	-	-	-	4.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

НТ-2

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл / төгрөгөөр /
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	1,449,080.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	1,449,080.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	1,449,080.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	449,080.00
210401	Бичиг хэрэг	-	129,080.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	320,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	1,449,080.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,449,080.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,449,080.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баяннуур сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлан, бүртгэлд гарсан алдаа зөрчилтэй, холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитын газрын аудитор Б.Энхтөр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Баяннуур сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баяннуур сумын ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын хүртээмж, чанар үр ашгийг дээшлүүлэх хүүхэд хөгжих, төлөвших, эрүүл аюулгүй, ээлтэй орчин бий болгох” гэсэн эрхэм зорилгыг тавьж ажилласны хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- ✓ Бага боловсрол
- ✓ Дунд боловсрол
- ✓ Бүрэн дунд боловсрол гэсэн зорилтуудыг хэрэгжүүлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар болон дотоод аудитын нэгжгүй болно. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баяннуур сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 1498010.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 22500.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 15700.0 мянган төгрөгөөр тогтоосон. Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баяннуур сумын ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлангийн тодруулгыг Сангийн сайдын 388 дугаар журмын 3-р хавсралтын дагуу бэлтгэж тайлагнасан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/Мян.төг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
----------	----------------	-----------------	----------

Б	1	2	3=2-1
Урьдчилж гарсан зардал			
Авлага	0	0	0
Бараа материал	71916.5	25290.8	46625.7
Үндсэн хөрөнгө	1623349.2	1619373.2	3975.9
Нийт хөрөнгө	1498008.2	1386457.3	111550.9
Өглөг	0	0	0
Хуримтлагдсан үр дүн	-69878.5	1154040.7	1084162.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1498008.2	1386457.3	111550.9

Авлага: Тайлант онд болон өмнөх онд эхний үлдэгдэл, эцсийн үлдэгдэлгүй байна.

Бараа материал: Оны эхний үлдэгдэл 71916.5 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 25290.8 мянган төгрөг болж өмнөх оноос 46625.7 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 49503.9 мянган төгрөгийн материалаар нэмэгдүүлж байна.

Үндсэн хөрөнгө: Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 1623349.2 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 1619373.2 мянган төгрөг болж өмнөх оноос 3975.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд үнэ төлбөргүй болон төсвийн хөрөнгөөр 15830.8 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, тайлант онд 2584.2 мянган төгрөгийн хөрөнгийг нэмж орлогод авсан байна.

Өр төлбөр: Өглөгийн дансанд оны эхний болон эцсийн үлдэгдэлгүй байна.

Санхүү байдлын, орлого үр дүнгийн, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлангууд, санхүүгийн тодруулга тайлангуудын өөрчлөлт, нягтлан бодох бүртгэлийн зарчмыг баримтлан, НБББ, санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүнгийн талаар болзошгүй өр төлбөр, авлагыг зэргийг тодруулж тайлагнасан болно.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Баяннуур сумын ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд улсын төсвөөс 587.6, орон нутгийн төсвөөс 139.3 сая төгрөг буюу нийт 726.9 сая төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөсөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Баяннуур сумын ерөнхий боловсролын сургууль нь 2021 он улсын төсвөөс 604.8, нэмэлт дансаар 1.4, орон нутгийн төсвөөс 107,8 сая төгрөг буюу нийт 714.1 сая төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 7961.9 сая төгрөгийг зарцуулж 38.7 сая төгрөгийн үлдэгдэлтэйгээр тайлагнажээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Баяннуур сумын ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд нэмэлт дансаар нийт 1.4 сая төгрөгийн санхүүжилт авснаас Бичиг хэргийн зардалд 0.1 сая төгрөг, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардалд 0.3 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 1.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Булган аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж математикийн кабинетыг бүрэн тоног төхөөрөмжөөр тохижуулах ажилд 10.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Хандив тусламжаар үндсэн хөрөнгийн дансанд 2.9 сая, бараа материалын дансанд үнэ төлбөргүй 1.07 сая төгрөгийн орлого авч тус тус тайлагнажээ.

Баяннуур сумын ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлангийн тодруулга тайлангаар харилцагч байгууллагуудтай авлага, өглөгийн тооцоогүй тайлагнасан байна. Мөн үндсэн хөрөнгийн данснаас 3.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг акталж устгажээ. Оны эцэст нийт зардлын данснаас 37.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн ажиллажээ.

3.8 Аудитын гол асуудал

Тус сумын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулж ажиллахдаа аудитын төлөвлөлтийн үе шатанд сонгосон нийт 12 эрсдэлийн хүрээнд горим сорилыг хэрэгжүүлэн ажиллалаа.

Хэрэгжүүлсэн горим сорилоор Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй буюу математикийн кабинет тохижуулах 10.0 сая төгрөгөөр тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл авч үндсэн хөрөнгөнд бүртгэсэн байна. Бараа материалын тооллогын баримтыг санхүүгийн тайлантай тулган үзэхэд эм боох материалын эцсийн үлдэгдэл 148.0 мянга, хүнсний материалын эцсийн үлдэгдэл 0.02 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан боловч тооллогоос хойш хөдөлгөөн хийгдсэн тайлбар өгсөн. Санхүүгийн тайлангийн төвлөрүүлэх орлогоос тогтмол зардлын хэмнэлтийг буцаах, үдийн хоол болон дотуур байрны хүүхдийн хоолны зардалд дутсан хүнсний үлдэгдэлд завсрын аудитаар төлбөрийн актыг орлого үр дүнгийн тайланд гарз тусгах бичилтийн алдааг залруулж, Сургуулийн үдийн хоол хийхэд 0.7 сая төгрөгийн 34 кг 3 баллон газ цэнэглэсэн нь Сангийн сайдын 190 дугаар тушаал "Зардлын эдийн засгийн ангилал, ашиглах заавар"-ын хавсралтыг мөрдөж ажиллаагүй, ажил гүйлгээний нотлох баримт болох нэмэгдсэн өртгийн албан татварын баримтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөнд зөвлөмж өгч, 4 жижүүрт нормын хувцас 0.23 сая төгрөгөөр худалдан авсан нь Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллаагүйд албан шаардлага, сургуулийн захирал Улаанбаатар хотод менежментийн сургалтанд сууж сургалтын төлбөр болох 0.3 сая төгрөгийг хувиасаа төлж, төлсөн төлбөрийг сургуулиас хичээл үйлдвэрлэлийн зардлаас гаргуулж авсан. Сургалтанд суулгах дээд гараас зөвшөөрөл, албан бичиг байхгүй байгаад холбогдох хууль журмын дагуу төлбөрийн акт тогтоож ажиллаа.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Үүний дагуу байгууллагын 2021 оны мэдээллийг шилэн дансанд бүрэн мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар 2 зөвлөмж өгч ажилласнаас зөвлөмжийн хэрэгжилтийг тайланг 2021 оны 06 дугаар сарын 15-ний өдрийн 17 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Жилийн эцсийн тооллогоор бараа материалын эцсийн үлдэгдлийг тулган баталгаажуулах, анхан шатны баримтын бүрдлийг сайжруулах, төлөвлөгдөөгүй ажил үйлчилгээнд анхан шатны баримт, зөвшөөрөлгүй хөрөнгө гаргахгүй байх тал дээр анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1.1 сая төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс, 0.3 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 0.23 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 0.6 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгч ажиллалаа.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайлангийн төвлөрүүлэх орлогоос тогтмол зардлын хэмнэлтийг буцаах, үдийн хоол болон дотуур байрны хүүхдийн хоолны зардалд дутсан хүнсний үлдэгдэлд завсрын аудитаар төлбөрийн актыг орлого үр дүнгийн тайланд гарзаар тусгах бичилтийн алдаанд залруулгыг хийсэн.

4.2 Төлбөрийн акт

Захирал УБ хотод менежментийн сургалтанд сууж сургалтын төлбөр болох 0.3 сая төгрөгийг хувиасаа төлж, төлсөн төлбөрийг сургуулиас хичээл үйлдвэрлэлийн зардлаас гаргуулж авсан. Сургалтанд суулгах дээд гараас зөвшөөрөл, албан бичиг байхгүй.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Сургуулийн 4 жижүүрт нормын хувцас 0.23 сая төгрөгөөр худалдан авсан нь Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага хүргүүлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Тогтмол зардалтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Сургуулийн үдийн хоол хийхэд 0.75 сая төгрөгийн 34 кг 3 баллон газ цэнэглэсэн нь Сангийн сайдын 190 дугаар тушаал "Зардлын эдийн засгийн ангилал, ашиглах заавар"-ын хавсралтыг мөрдөж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 190 дугаар тушаал хавсралтыг мөрдлөг болгож ажиллах.

2. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Ажил гүйлгээний нотлох баримт болох нэмэгдсэн өртгийн албан татварын баримтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан

шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг баримталж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 02 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/ д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		/сая/төгрөгөөр/ Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баяннуур сумын ЕБС	5	1.13	1	0	1	0.3	1	0.23	2	0.6